



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/449

Мандалговь


Мал, тэжээвэр амьтдын  
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"г", 29.2 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны 61 дүгээр тушаал, Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 8 -ний өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах аймгийн комиссыг нэг дүгээр хавсралтаар, "Сумдын мал, тэжээвэр амьтдын тооллогын явцад хяналт тавьж ажиллах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг хоёрдугаар хавсралтаар, тооллогын хяналтын зардлыг гуравдугаар хавсралтаар, багийн Засаг дарга нарт жилийн эцсийн мал тооллогын сургалтанд хамрагдсан унааны зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд нэгэн зэрэг явуулж, мал, тэжээвэр амьтдыг нүдээр үзэж нэг бүрчлэн тоолох ажлыг Үндэсний Статистикийн хорооноос баталсан заавар удирдамжийн дагуу зохион байгуулахыг комиссын нарийн бичгийн дарга (Б.Энхтуяа)-д, мал тооллогыг хугацаанд нь хариуцлагатай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналт хийхэд шаардагдах зардалд 4,009,600 (Дөрвөн сая есөн есөн мянга зургаан зуун) төгрөг, багийн Засаг дарга нарт жилийн эцсийн мал тооллогын сургалтанд хамрагдсан унааны зардал 1,055,000 (Нэг сая тавин таван мянган) төгрөг нийт 5,064,600 (Таван сая жаран дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

